



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 12 сарын 16 өдөр

Дугаар 574

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас
хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.4.3, 6.4.4, 6.4.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, Улсын төсвийн 2018 хөрөнгө оруулалтаар шинэчлэгдэж байгаа нийт 82,265,216.18 (наян хоёр сая хоёр зуун жаран таван мянга хоёр зуун арван зургаан төгрөг арван найман мөнгө) төгрөг балансын үнэ, 24,934,144.07 (хорин дөрвөн сая есөн зуун гучин дөрвөн мянга нэг зуун дөчин дөрвөн төгрөг долоон мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Батгэрэл, “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Д.Баярсайхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай

2.1. Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, устгах, сэлбэгээр худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Акталсан хөрөнгийг худалдсанаас олох орлогыг (худалдахтай холбогдон гарсан зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу компанийн дансанд төвлөрүүлэх;

2.3. Ашиглаж болох материалыг үнэ тогтоон бүртгэх

2.4. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.5. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

0001114

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны Хүдүгээр сарын 16-ны өдрийн
544 дугаар тогтоолын хавсралт

"УЛААНБААТАР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/Д	Хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон огноо	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгж үнэ	Балансын үнэ (төгрөгөөр)	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
1	ХТП-199 барилга 21-р сургууль барилга	1995/02/25	ш	1	12,713,994.08	12,713,994.08	225,015.58	12,488,978.50
НИЙТ								
1	21 р сургууль ХТП 199 Газардуулах байгууламж (газар доорхи болон ил байгууламж	2005/01/01	ш	1	2,478,000.00	2,478,000.00	2,288,239.17	189,760.83
2	6-10 кВ-ын хөндийрүүлэгч	1995/02/25	ш	25	2,794.21	69,855.25	28,709.00	41,146.25
3	6-10 кВ-ын гүүрэн шин	1995/02/25	ш	2	152,411.64	304,823.28	125,570.82	179,252.46
4	6-10 кВ-ын хуурай салгуур	1995/02/25	ш	4	91,446.99	365,787.96	211,589.44	154,198.52
5	Гал хамгаалагч	1995/02/25	ш	5	19,813.51	99,067.55	57,292.70	41,774.85
6	Рубильник	1995/02/25	ш	6	165,000.00	990,000.00	990,000.00	-
7	6-10 кВ-ын КСО маягийн ячейк	1995/02/25	ш	4	88,906.79	355,627.16	146,490.32	209,136.84
8	6-10 кВ-ын кабель (трансформаторын оруулгын)	1995/02/25	ш	5	4,572.35	22,861.75	10,848.58	12,013.17
9	6-10 кВ-ын ачаалал таслагч	1995/02/25	ш	2	190,514.55	381,029.10	220,394.72	160,634.38
10	21-р сургууль ХТП-199 /герман тоноглол/ 2013	1995/02/25	ш	1	38,415,178.82	38,415,178.82	13,488,051.00	24,927,127.82
11	ХТП-199 Трансформатор S- 11 630/10	1995/02/25	ш	1	19,525,720.95	19,525,720.95	5,228,633.93	14,297,087.02

12	ХТП-199 Трансформатор S-11 630/11	1995/02/25	ш	1	6,543,270.28	6,543,270.28	1,913,308.81	4,629,961.47
нийт дүн			ш	57	-	69,551,222.10	24,709,128.49	44,842,093.61
НИЙТ ДҮН						82,265,216.18	24,934,144.07	57,331,072.11
						(наян хоёр сая хоёр зуун жаран таван мянга хоёр зуун арван зургаан төгрөг арван найман мөнгө)	(хорин дөрвөн сая есөн зуун гучин дөрвөн мянга нэг зуун дөчин дөрвөн төгрөг долоон мөнгө)	(тавин долоон сая гурван зуун гучин нэгн мянга далан хоёр төгрөг арван нэгн мөнгө)